БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/101/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2022 он | Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас:70642580 Цахим хаяг: Ankhbayrd@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн<br>Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт....2
1. Аудитын тайлангийн дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....11
3. Аудитын тайлан....12
3.1 Ерөнхий зүйл....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....13
3.4 Материаллаг байдал....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....16
3.8 Аудитын гол асуудал....16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....17
4. Аудитын илрүүлэлт....17
4.1 Залруулсан алдаа....17
4.2 Төлбөрийн акт....17
4.3 Албан шаардлага....17
4.4 Зөвлөмж....17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Аудитын тайлангийн дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 94

танай ______ ны № ______ т

ХЯЛГАНАТ ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.ЦОЛМОНБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020157

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **80,676,616.91** | **42,006,814.31** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 80,676,616.91 | 42,006,814.31 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,637,770.00 | 4,230,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,209,570.00 | 4,024,400.00 |
| 35130 | Эм боох материал | 428,200.00 | 206,100.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,727,586.00 | 4,168,886.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 71,311,260.91 | 33,607,428.31 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 22,630,684.91 | 20,685,928.31 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,268,572.00 | 1,029,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 540,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 5,064,004.00 | 2,667,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,808,000.00 | 9,224,300.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,548,450,213.44** | **1,478,862,375.64** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,548,450,213.44 | 1,478,862,375.64 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,483,713,213.18 | 1,414,510,375.71 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,454,836,412.56 | 1,454,836,412.56 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (133,538,214.90) | (200,324,128.98) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 188,501,730.65 | 196,207,355.54 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (96,177,368.68) | (117,220,149.80) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 78,160,046.06 | 95,025,346.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,063,822.72) | (34,679,607.88) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,228,875.00 | - |
| 39217 | Ном | 12,765,555.21 | 20,665,148.21 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 64,737,000.26 | 64,351,999.93 |
| 39301 | Програм хангамж | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (124,999.74) | (510,000.07) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 63,262,000.00 | 63,262,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,629,126,830.35** | **1,520,869,189.95** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,629,126,830.35** | **1,520,869,189.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,629,126,830.35 | 1,520,869,189.95 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,345,438,447.10 | 2,345,438,447.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,345,438,447.10 | 2,345,438,447.10 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (978,496,506.33) | (1,086,754,146.73) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (978,496,506.33) | (978,496,506.33) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (108,257,640.40) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 262,184,889.58 | 262,184,889.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,629,126,830.35** | **1,520,869,189.95** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,368,183,690.00** | **1,394,479,426.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,066,890.00** | **25,065,916.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 21,066,890.00 | 25,065,916.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,066,890.00 | 25,065,916.40 |
| 1200044 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө | | 16,515,718.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -бараа материал | 21,066,890.00 | 8,550,198.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,347,116,800.00** | **1,369,413,509.68** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,062,619,000.00 | 1,064,902,591.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,062,619,000.00 | 1,064,902,591.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 284,497,800.00 | 304,510,918.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 284,497,800.00 | 304,510,918.68 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,413,781,743.67** | **1,499,275,489.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,413,781,743.67** | **1,499,275,489.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,334,754,195.36 | 1,443,510,176.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 799,004,383.93 | 815,109,342.69 |
| 210101 | Үндсэн цалин | 549,325,105.56 | 579,255,311.02 |
| 210102 | Нэмэгдэл | 174,837,833.37 | 174,591,895.67 |
| 210104 | Урамшуулал | 74,841,445.00 | 61,262,136.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 105,125,962.12 | 101,964,938.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,261,394.25 | 71,967,550.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,223,593.42 | 7,656,718.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,575,494.48 | 6,056,885.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,642,345.64 | 1,484,005.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,423,134.33 | 14,799,779.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 283,385,175.64 | 301,353,918.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,732,225.64 | 6,102,718.68 |
| 210302 | Түлш, халаалт | 263,958,150.00 | 282,556,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,694,800.00 | 12,694,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,118,130.00 | 34,673,257.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 616,675.00 | 1,618,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,550,000.00 | 3,342,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 480,200.00 | 2,010,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 241,700.00 | 400,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,513,560.00 | 1,959,640.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,712,095.00 | 18,787,915.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,700.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,200.00 | 6,553,652.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,479,766.00 | 27,664,880.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 385,400.00 | 934,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,451,166.00 | 24,606,280.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,643,200.00 | 2,124,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 964,400.00 | 2,623,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 964,400.00 | 2,623,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 332,000.00 | 449,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 332,000.00 | 449,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,027,800.00 | 3,913,090.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,027,800.00 | 3,913,090.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 106,316,577.67 | 155,757,750.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 339,100.00 | 33,552,860.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,376,970.00 | 13,798,111.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 100,600,507.67 | 108,406,779.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 79,027,548.31 | 55,765,312.81 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,813,750.00 | 22,290,070.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,213,750.00 | 21,490,070.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 61,213,798.31 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 61,213,798.31 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 33,475,242.81 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 33,475,242.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(45,598,053.67)** | **(104,796,063.63)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 20,579,543.84 | 3,461,576.77 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 20,579,543.84 | 3,461,576.77 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (20,579,543.84) | (3,461,576.77) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(66,177,597.51)** | **(108,257,640.40)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,345,438,447.1 | 262,184,889.6 | (923,013,501.9) | | 1,684,609,834.7 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,345,438,447.1** | **262,184,889.6** | **(923,013,501.9)** | **-** | 1,684,609,834.7 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (55,483,004.4) | | (55,483,004.4) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-** | **2,345,438,447.1** | **262,184,889.6** | **(978,496,506.3)** | **-** | 1,629,126,830.4 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **нээрх үлдэгдэл** | | | | | |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,345,438,447.1** | **262,184,889.6** | **(978,496,506.3)** | **-** | 1,629,126,830.4 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,345,438,447.1** | **262,184,889.6** | **(978,496,506.3)** | **-** | 1,629,126,830.4 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (108,257,640.4) | | (108,257,640.4) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,345,438,447.1** | **262,184,889.6** | **(1,086,754,146.7)** | **-** | 1,520,869,190.0 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,347,116,800.00** | **1,369,413,509.68** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,347,116,800.00** | **1,369,413,509.68** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,062,619,000.00 | 1,064,902,591.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,062,619,000.00 | 1,064,902,591.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 284,497,800.00 | 304,510,918.68 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 284,497,800.00 | 304,510,918.68 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,327,743,030.00** | **1,343,648,709.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,327,743,030.00** | **1,343,648,709.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,247,474,051.69** | **1,288,056,066.87** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 799,004,383.93 | 815,109,342.69 |
| 210101 | Үндсэн цалин | 549,325,105.56 | 579,255,311.02 |
| 210102 | Нэмэгдэл | 174,837,833.37 | 174,591,895.67 |
| 210104 | Урамшуулал | 74,841,445.00 | 61,262,136.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 105,125,962.12 | 101,964,938.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,261,394.25 | 71,967,550.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,223,593.42 | 7,656,718.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,575,494.48 | 6,056,885.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,642,345.64 | 1,484,005.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,423,134.33 | 14,799,779.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 283,385,175.64 | 301,353,918.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,732,225.64 | 6,102,718.68 |
| 210302 | Түлш, халаалт | 263,958,150.00 | 282,556,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,694,800.00 | 12,694,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,869,800.00 | 9,800,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 453,200.00 | 449,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,550,000.00 | 3,292,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 480,200.00 | 1,655,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 411,400.00 | 359,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,200,000.00 | 2,149,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,775,000.00 | 1,894,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,315,000.00 | 24,573,276.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 389,600.00 | 535,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 17,970,600.00 | 22,197,176.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,954,800.00 | 1,840,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,063,400.00 | 3,177,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 20,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,063,400.00 | 3,157,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 332,000.00 | 449,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 332,000.00 | 449,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,002,800.00 | 8,160,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,002,800.00 | 8,160,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,375,530.00 | 23,466,791.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,880,000.00 | 16,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,495,530.00 | 6,966,791.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **80,268,978.31** | **55,592,642.81** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,055,180.00 | 22,117,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,455,180.00 | 21,317,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 61,213,798.31 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 61,213,798.31 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 33,475,242.81 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 33,475,242.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,373,770.00** | **25,764,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,373,770.00** | **25,764,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,373,770.00** | **25,764,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 19,373,770.00 | 25,764,800.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 4,249,970.00 | 21,499,800.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 15,123,800.00 | 4,265,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(19,373,770.00)** | **(25,764,800.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,341,638,900.00 | 1,312,208,375.87 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,341,638,900.00 | 1,286,443,575.87 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,313,450,400.00 | 1,264,326,175.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 825,772,800.00 | 815,109,342.69 |
| 210101 | Үндсэн цалин | 528,062,000.00 | 579,255,311.02 |
| 210102 | Нэмэгдэл | 234,675,100.00 | 174,591,895.67 |
| 210104 | Урамшуулал | 63,035,700.00 | 61,262,136.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 110,929,300.00 | 101,964,938.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 77,898,400.00 | 71,967,550.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,147,700.00 | 7,656,718.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,716,200.00 | 6,056,885.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,651,500.00 | 1,484,005.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,515,500.00 | 14,799,779.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 301,354,200.00 | 301,353,918.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,103,000.00 | 6,102,718.68 |
| 210302 | Түлш, халаалт | 282,556,400.00 | 282,556,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,694,800.00 | 12,694,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,400,900.00 | 9,400,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 449,500.00 | 449,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,292,700.00 | 3,292,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,655,000.00 | 1,655,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 359,700.00 | 359,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,749,300.00 | 1,749,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,894,700.00 | 1,894,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,349,600.00 | 24,573,276.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 535,200.00 | 535,200.00 |
| 210502 | Хоол, хүнсы | 29,973,500.00 | 22,197,176.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,840,900.00 | 1,840,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,897,000.00 | 3,177,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,740,000.00 | 20,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,157,000.00 | 3,157,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 449,500.00 | 449,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 449,500.00 | 449,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 160,200.00 | 160,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 160,200.00 | 160,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,136,900.00 | 8,136,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,636,900.00 | 6,636,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,188,500.00 | 22,117,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,188,500.00 | 22,117,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,388,500.00 | 21,317,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **25,764,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 25,764,800.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 21,499,800.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 4,265,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,347,706,400.00 | 1,345,683,618.68 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,043,195,200.00 | 1,041,172,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,043,195,200.00 | 1,041,172,700.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 304,511,200.00 | 304,510,918.68 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 304,511,200.00 | 304,510,918.68 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **360,000.00** | **23,729,891.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **360,000.00** | **23,729,891.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 360,000.00 | 23,729,891.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 400,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 8,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 8,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 360,000.00 | 15,329,891.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 360,000.00 | 15,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 329,891.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 360,000.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 360,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 360,000.00 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь "Суралцагч нэг бүрийг авьяаслаг, оюунлаг, спортлог иргэн болгон төлөвшүүлнэ." зорилтоо тодорхойлжээ.

Тайлант онд дараах зорилтод чиг үүргийг тодорхойлжээ.Үүнд:

- Салбарын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ
- Бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, технологийг хөгжүүлэх
- .Байгууллагын хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах, багшийн хөгжлийг дэмжих
- Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцагч, багш ажилтаныг эрүүл, аюулгүй таатай орчинд сурч төлөвших, ажиллах нөхцлийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Бага дунд боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Сангийн сайдын тушаал 2017.06.22ны №216
- МУ-ын Засгийн Газрын тогтоол №05, №06
- Спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалын хавсралт / мэргэжлийн зэрэг олгох, хасах журам,
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 1,434,357.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,515.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 15,060.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108257,64 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | - | - | - |
| **Авлага** | - | - | - |
| **Урьдчилгаа** | - | - | - |
| **Бараа материал** | 80,676.60 | 42,006.80 | (38,669.80) |
| **Үндсэн хөрөнгө** | 1,548,450.20 | 1,478,862.40 | (69,587.80) |
| Нийт хөрөнгө | 1,629,126.80 | 1,520,809.20 | (108,317.60) |
| **Өр төлбөр** | - | - | - |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 1,629,126.80 | 1,520,809.20 | (108,317.60) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,629,126.80 | 1,520,809.20 | (108,317.60) |

Бараа материалын дансны үлдэгдэл 42,006.8 мянган төгрөг болж 38,669.8 мянган төгрөгөөр буурсан нь ашиглах боломжгүй болсон 6,553.6 мянган төгрөгийн материалыг байгууллагын даргын тушаалаар данснаас хассан нь шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд оны эцэст 11-12 сард “Хөгжлийн хөтөлбөр” төслийн санхүүжилт 10 сард ирж 8,000.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь бараа материалын үлдэгдэл өндөр гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,831,596.3 мянган төгрөг болж 28,241.7 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 12,845.0 мянган төгрөгийн спорт заалны сургалтын хэрэглэгдэхүүн, төсвийн хөрөнгөөр 4,045.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 13,000.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэц, мөн үнэ төлбөргүйгээр 3,640.7 мянган төгрөгийн ном сурах бичиг худалан авсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар, урсгал төсвийн худалдан авалтаар 25,764.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 16,515.7 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 4,228.8 мянган төгрөг, акталсан 14,038.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,520,869.2 мянган төгрөг болж 108,257.6 мянган төгрөгөөр буурсан нь өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 14,038.9 мянгантөгрөгийн үндсэн хөрөнгө акталсан дахин үнэлгээний зөрүү дансанд бууруулах бичилт хийсэн, тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2021 Оны санхүүгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,605.0 мянган төгрөгөөр буюу 0,01 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 16,515.7,үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 8,550.2 мянган төгрөгийн орлого байна.

Энэ нь БСШУЯ-наас спорт заалны сургалтын хэрэглэгдэхүүн 14,175.0, ном сурах бичиг 3,670.7, БЧШТөслийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн 299.5, Жайко ОУ-ын байгууллагаас автомакс, ариутгалтын бодис 147.2, аймгийн боловсролын газраар тусгаарлах өрөөний багц 2 ш буюу 247.5, “Эко-хөдөлмөр зуслан”-гийн ажилд тосгоны аж ахуйн нэгж, байгууллагууд иргэдийн өгсөн эд материалын 6,526.0 мянган төгрөгийн хандив зэрэг нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 85,493.7 мянган төгрөгөөр буюу 0,06 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эргэлтийн хөрөнгийн дансанд он удаан жил ашиглагдахгүй нэр төрөл, үлдэгдэлд нөлөөлж байсан 22,118.7 мянган төгрөгийн ашиглагдахгүй эд материал, 14,038.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хасалт хийгдсэн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 3,461.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь шалтгаалсан байна

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,236,647.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,236,647.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөл нь санхүүгийн жилдээ төсвийн тодотголд санал оруулж цалин, НДШ-ийн зардал дээр хуваарийн өөрчлөлт оруулж 124144,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, тогтмол зардлыг 308,250.2 мян, төгрөг байсныг 3,739.0 мян, төгрөгөөр бууруулж 1,345,683.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,345,683.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 304,511.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 104,117.0 тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 304,511.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого тусшхй зориулалтын шилжүүлэг 1,041,173.0 мянган төгрөг нийт 1,345,683.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,320,648.7 мянган төгрөгийг зарцуулж 33,475.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсролын газраас ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зориулан ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 400.0, боловсролын үнэлгээний шалгалтын хэрэглэгдэхүүний зардалд 329.8, Тогтвортой Хөгжлийн боловсрол II төслийн санхүүжилт 15,000.0, БСШУЯ-ны сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5-р шат “Хөгжлийн хөтөлбөр” төслийн санхүүжилт 8,000.0, нийт 23,729.8 мянган төгрөгийн санхүүжилтээс бүрдүүлжээ.

Үүнээс 23,729.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 117 мэдээлэл оруулахаас 117 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 1 мэдээллийн хугацаа нь болоогүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн;
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,045.0 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4 дэх заалттай нийцээгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд нийт 966.7 мянган төгрөгийн зөрчилд 966.7 мянган төгрөгийн албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,045.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,045.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогүй.

### 4.3 Албан шаардлага

Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,045,000.00 төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Цалингийн зардалтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Халаалтын зардлаас 1000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сангийн сайдын 2018 оны 6 сарын 8 өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.1.2 дахь заалт, сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 190 -р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Сангийн сайдын 2018 оны 6 сарын 8 өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан

төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.1.2 дахь заалт, сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 190 -р тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хялганат тосгоны сургууль | 2 | 5,045.0 | | | | | 1 | 4,045.0 | 1 | 1,000.0 |